



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/28

Батноров сум

ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. XVII дугаар жарны "Элдэв эрдэнэт" хэмээх Модон Могой жилийн сар шинийн баярыг тохиолдуулан Монгол морин спорт уяачдын холбооны салбар холбоо болох Батноров сумын "Норовын хүлэг" уяачдын холбооны 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн хурдан морь уяж сойх эрдэмд амжилт гаргаж болзол хангасан дараах уяачдад "Сумын алдарт уяач" цол олгосугай.

- "Зосын хүлэг" галын уяач Сумъяагийн Өлзийбаатар
- "Дэлгэрэх хурд" галын ахмад уяач Гончигсүрэнгийн Гантулга
- "Дэлгэрэх хурд" галын уяач Жигжидийн Баатардорж
- "Шандаст хүлэг" галын уяач Гомбосүрэнгийн Отгонжаргал

2. Сумын алдарт уяач цол олгосон уяачдад цолны үнэмлэх, энгэрийн тэмдэг олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Борчулуун)-д даалгасугай.

3. Сумын алдарт уяач цол авсан уяачдын цол чимгийг бүртгэлжүүлж, малгай залааг олгож стандартыг мөрдөж ажиллахыг Норовын хүлэг уяачдын холбооны тэргүүн (Г.Тайванжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА  ОТГОНБАЯР

230425098